



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 603

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Шүүхийн тамгын газруудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 10 нэрийн, нийт 183,566,104.22 (нэг зуун наян гурван сая таван зуун жаран зургаан мянга нэг зуун дөрвөн төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслүүдийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг болон харьяа Шүүхийн тамгын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА, АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ТАМГЫН
ГАЗРУУДЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ

№	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Балансын үнэ (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэх өртөг (төгрөгөөр)	Худалдах доод үнэ (төгрөгөөр)
1	УАЗ-469 47-77 БӨА	2011	20,700,000.00	20,700,000.00	-	5,000,000
2	Тоёота Прадо-95 66-94 ДУА	2012	5,000,000.00	5,000,000.00	-	5,000,000
3	Хьюндай Соната 6, 03-58 УНУ	2007	31,110,000.00	31,110,000.00	-	4,000,000
4	МITSUBISHI PAJERO, 05-87 УНУ	2008	14,100,000.00	14,100,000.00	-	4,000,000
5	Соната-6NF, 01-92 УНП	2006	21,700,000.00	21,700,000.00	-	2,500,000
6	Истана, 50-70 УБС	2006	17,101,652.00	17,101,652.00	-	2,500,000
7	Хьюндай соната 6, 03-88 УБУ	2008	25,221,910.00	25,221,910.00	-	4,000,000
8	Ланд Крузер 105, 03-94 УБЗ	11/30/2020	25,000,000.00	25,000,000.00	-	15,000,000
9	Суудлын УАЗ31519 маркийн, 12-85 ХОА	2012	4,632,542.22	4,632,542.22	-	5,000,000
10	Тоёота Вероса, 00-06 ОРА	2001	19,000,000.00	19,000,000.00	-	3,500,000
Нийт дүн			183,566,104.22	183,566,104.22	-	50,500,000
			(нэг зуун наян гурван сая таван зуун жаран зургаан мянгө нэг зуун дөрвөн төгрөг хорин хоёр мөнгө)	(нэг зуун наян гурван сая таван зуун жаран зургаан мянгө нэг зуун дөрвөн төгрөг хорин хоёр мөнгө)		(тавин сая таван зуун мянга)